



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 05 дугаар сарын 28
№20 (1316)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

253. Авлигатай тэмцэх газрын албан
хаагчийн албан тушаалын цалингийн
хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 47

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

254. Журам батлах тухай Дугаар 25



᠘᠙᠗.	ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠰᠤᠨ ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠰᠤᠨ ᠲᠤᠨ ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠰᠤᠨ	ᠬᠡᠭᠡ
᠘᠙᠘.	ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠰᠤᠨ ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠰᠤᠨ ᠲᠤᠨ ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠰᠤᠨ	ᠬᠡᠭᠡ
	ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠰᠤᠨ	



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар
хот

Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол баталсантай холбогдуулан “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 92 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Монгол Улсын Их Хурлын 2024 оны
47 дугаар тогтоолын хавсралт

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН АЛБАН ХААГЧИЙН
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

Д/д	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ /төгрөгөөр/
1	Авлигатай тэмцэх газрын дарга	4 772 128
2	Авлигатай тэмцэх газрын дэд дарга	4 445 241
3	Хэлтсийн дарга	4 261 658
4	Албаны дарга	4 037 154
5	Ахлах ажилтан	3 842 702
6	Ажилтан	3 622 339
7	Туслах ажилтан	2 069 067

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 38.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Нэмэлт урамшуулалд шаардагдах санхүүжилтийг 2024 оны батлагдсан төсөвт багтаан олгох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ЭНХ-АМГАЛАН

Засгийн газрын 2024 оны 01 дүгээр
сарын 17-ны өдрийн 25 дугаар
тогтоолын хавсралт

**БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
БОЛОН БАГШИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ЧАНАР, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР
ДҮНД ҮНДЭСЛЭН ОЛГОХ НЭМЭЛТ УРАМШУУЛЛЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг зүйл

1.1.Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж (цаашид “сургалтын байгууллага” гэх)-ийн гүйцэтгэл, чанар, үр дүн болон цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш (цаашид “багш” гэх)-ийн ажлын гүйцэтгэл, чанарын үнэлгээний үр дүнд тус тус үндэслэн нэмэлт урамшуулал (цаашид “урамшуулал” гэх) олгох үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2.Энэ журмын зорилго нь сургалтын байгууллагын гүйцэтгэл, чанар, үр дүнгийн үнэлгээг үндэслэн урамшуулал олгох, сургалтын байгууллагын менежмент, багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнг тасралтгүй сайжруулахад оршино.

1.3.Сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнгийн үнэлгээг үндэслэн урамшуулал олгох үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн, ил тод, шударга, үр дүн, албан ёсны тоо баримт, мэдээлэл, нотолгоонд суурилсан, боловсролын харилцаанд оролцогч талуудын оролцоог хангасан, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчим баримтална.

**Хоёр.Сургалтын байгууллагын гүйцэтгэл, чанар, үр дүнгийн
үнэлгээний зохион байгуулалт**

2.1.Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэл, чанар, үр дүнгийн үнэлгээг доор дурдсан шалгуур, үзүүлэлтийн дагуу цуглуулсан үнэлгээний мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох онооны жин харьцааг баримтлан жил бүр зохион байгуулна:



№	Шалгуур	Онооны жин/ харьцаа	Шалгуурыг үнэлэх үзүүлэлт
1.	Байгууллагын менежмент, удирдлагын манлайлал	15	- Багш, ажилтнаас авах асуулгын үр дүн; - Боловсролын газар, хэлтсийн дарга, мэргэжилтнээс авах асуулгын үр дүн; - Суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчдаас авах сэтгэл ханамжийн асуулгын үр дүн.
2.	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн	25	- Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааны ахиц, үр дүн; - Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн сурлагын ахиц, үр дүн.
3.	Хүүхдийн хөгжил, хамгаалал	20	- Цэцэрлэгийн хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагааны ахиц, үр дүн; - Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийг хөгжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагааны ахиц, үр дүн.
4.	Хүний нөөцийн бодлого, багш, ажилтны тасралтгүй хөгжил	20	- Багшийн мэргэжлийн хөгжлийн ахиц, үр дүн; - Багш, ажилтнаас авах асуулгын үр дүн; - Боловсролын газар, хэлтсийн мэргэжилтнээс авах асуулгын үр дүн; - Боловсролын салбарын статистик мэдээ (БМТТ-ийн мэдээлэлд үндэслэх)-ний холбогдох үзүүлэлт.
5.	Сургалтын орчин бүрдүүлэлт	12	- Сургалтын орчин бүрдүүлэлт, хоол үйлдвэрлэл үйлчилгээ, эрүүл ахуйн болон дотуур байр, ариун цэврийн байгууламжийн хүртээмж, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн шаардлага, стандартын хэрэгжилтийн байдлыг үнэлэх хуудас, түүний дагуу хийсэн үнэлгээний үр дүн; - Боловсролын салбарын статистик мэдээ (БМТТ-ийн мэдээлэлд үндэслэх)-ний холбогдох үзүүлэлт; - Суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчдын сэтгэл ханамжийн асуулгын үр дүн.
6.	Эцэг, эх, олон нийтийн түншлэл, оролцоо	8	- Суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчдаас авах сэтгэл ханамжийн асуулгын үр дүн; - Багш, ажилтнаас авах асуулгын үр дүн.



2.2.Энэ журмын 2.1-д заасан шалгуур, үзүүлэлтийн “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн”, “хүүхдийн хөгжил, хамгаалал”, “Багшийн мэргэжлийн хөгжлийн ахиц, үр дүн” гэсэн шалгуур, үзүүлэлтийг үнэлэх мэдээлэл нь Боловсролын ерөнхий хуулийн 26.1.2-т заасан багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмын дагуу тухайн жилд хийгдсэн хөндлөнгийн үнэлгээний дундаж үр дүн байна.

2.3.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үр дүнгийн үнэлгээний мэдээлэл цуглуулах ажлыг боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагаас боловсруулсан удирдамжийн дагуу тухайн байгууллагын удирдах ажилтныг арга зүй, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.

2.4.Энэ журмын 2.1, 2.2-т заасны дагуу боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үр дүнд хийсэн үнэлгээний үр дүнд үндэслэн сургалтын байгууллагыг нийслэл, аймгийн төв, сум-баг гэсэн гурван байршил (цаашид “кластер” гэх)-аар доор заасан 5 түвшинд ангилж, мэдээллийн системд байршуулна:

Индексийн түвшин	Тухайн кластер дахь цэцэрлэг/сургуулийн эрэмбийн хувь /N/
I түвшин	$95 \leq N$
II түвшин	$85 \leq N < 95$
III түвшин	$70 \leq N < 85$
IV түвшин	$60 \leq N < 70$
V түвшин	$N \leq 60$

2.5.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн эрэмбийн хувь /N/ гэдэгт тухайн кластер дахь сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн тархалтын дунджаас хэдэн хувиас дээгүүр байрлаж байгааг илэрхийлэх хувь (проценталь хувь) байна.

2.6.Мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнгийн үнэлгээ хийх үйл ажиллагааг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.

2.7.Энэ журмын 2.6-д заасан журамд мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнгийн үнэлгээний үр дүнд олгох нэмэлт урамшууллын хувь хэмжээг тусгана.

Гурав.Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшуулал

3.1.Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд доор дурдсан нэмэлт урамшууллыг жилд нэг удаа олгоно:

Индексийн түвшин	Нэмэлт урамшууллын хэмжээ (тухайн байгууллагад хувьсах зардлаар тооцож олгосон нийт төсвөөс тооцох хувь)	
	Цэцэрлэг	Ерөнхий боловсролын сургууль
I	5%	4%
II	4%	3%
III	3%	2%
IV	2%	1%

3.2.Энэ журмын 3.1-д заасан нэмэлт урамшууллыг тухайн байгууллагын менежментийг сайжруулах үйл ажиллагаа болон нийт албан хаагчийг урамшуулахад зарцуулна.

3.3.Нэмэлт урамшууллын 35-аас доошгүй хувийг сургалтын байгууллагын менежментийг сайжруулах үйл ажиллагаанд зарцуулах бөгөөд үйл ажиллагааг багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэж батална.

3.4.Нэмэлт урамшууллын 65 хүртэлх хувийг албан хаагчдыг урамшуулахад зарцуулах бөгөөд урамшууллын хэмжээг ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнд үндэслэн доор дурдсан харьцааг баримтлан цэцэрлэг, сургуулийн зөвлөлөөр тус тус хэлэлцэж батална:

№	Урамшуулал олгох албан хаагч	Нэмэлт урамшууллын зардлаас ногдох хувь
1.	Удирдах ажилтан, бусад албан хаагч	40%
2.	Багш нар	60%

3.5.Боловсролын ерөнхий хуулийн 26.1.2-т заасан багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын үнэлгээний үр дүнд үндэслэн олгох урамшууллыг албан тушаалын сарын үндсэн цалингаас доор дурдсан хувь хэмжээгээр тооцож, улирал тутам олгоно:



Багшийн үнэлэгдсэн индексийн түвшин	Тухайн кластер дахь багшийн эрэмбийн хувь /M/	Албан тушаалын сарын үндсэн цалингаас урамшуулал тооцож олгох хэмжээ/хувь
I түвшин	$95 \leq N$	40%
II түвшин	$85 \leq M < 95$	25%
III түвшин	$75 \leq M < 85$	20%
IV түвшин	$60 \leq M < 75$	15%

3.6. Мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтны ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнг үнэлэх үйл ажиллагааг энэ журмын 2.6-д заасан журмаар зохицуулна.

Дөрөв. Сургалтын байгууллага, багшид олгох нэмэлт урамшуулал олгох зохион байгуулалт

4.1. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 3.1, 3.5-д заасан хувь хэмжээг баримтлан цэцэрлэг, сургууль, багшид нэмэлт урамшуулал тооцож олгох үйл ажиллагааг арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангана.

4.2. Цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал албан хаагчийн албан тушаалын чиг үүрэгт хамаарах ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнд үндэслэн энэ журмын 3.2-3.5-д заасны дагуу багш, ажилтанд олгох нэмэлт урамшууллын хувь хэмжээ, хугацааг заасан шийдвэр гаргана.

4.3. Багш нь төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, сургуульд ижил түвшний албан тушаалд шилжин ажилласан болон амралт, эмнэлгийн магадлаатай байгаа тохиолдолд энэ журмын 4.2-т заасан шийдвэрийн дагуу урамшууллыг үргэлжлүүлэн олгоно.

4.4. Багш нь урамшуулал авч байх хугацаандаа өөр ажилд шилжин ажилласан тохиолдолд урамшууллыг зогсооно.

Тав. Бусад

5.1. Сургалтын байгууллагын удирдах ажилтан, үнэлгээний багийн гишүүд, боловсролын газар, хэлтсийн албан хаагч, хяналтын ажилтан нь үнэлгээ хийх явцад хөндлөнгөөс нөлөөлж, үнэлгээний дүн бодитой бус гарахад хүргэсэн нь нотлогдсон тохиолдолд тухайн үнэлгээг хүчингүйд тооцно.



5.2.Энэ журмын 5.1-д заасан талууд үнэлгээний мэдээллийн систем дэх тоон өгөгдөл болон хүний хувийн мэдээллийн нууцлалыг хангаж ажиллана. Үнэлгээний үр дүнг журамд зааснаас бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

5.3.Нэмэлт урамшуулал олгохтой холбогдон гарах маргааныг Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагын дүгнэлтийг үндэслэн Боловсролын ерөнхий газар шийдвэрлэнэ.

5.4.Боловсролын ерөнхий газар нь сургалтын байгууллага болон багшид олгох нэмэлт урамшууллын хэрэгжилтэд жил тутам хяналт-шинжилгээ хийж, дүнг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

---o0o---



№	Műhelynevek	Műhelynevek és Dokumentumok	Műhelynevek és Dokumentumok
06	<p>– Vándorújságok – Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>	<p>– Vándorújságok – Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>	<p>– Vándorújságok – Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>
07	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>
08	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>
09	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>
10	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>
11	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>
12	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>	<p>– Műhelynevek – Műhelynevek – Műhelynevek</p>

